



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 11 өдөр

Дугаар A/156

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Т

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/281 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2017 оны 08-р сарын 26-ны өдрийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх "Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн гаүрын халаалтын тогооны засварын ажил"-ын гүйцэтгэгчээр "Зууны сод хийц" ХХК-ийг сонгон 31,255,352 /гучин нэгэн сая хоёр зуун тавин таван мянга гурван зуун тавин хоёр/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Зууны сод хийц" ХХК –ний захиралд үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхжаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



ЦЭРДЭНЭСҮРЭН

0300480